



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот










Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("Хурал")-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.2 дох заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дох заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.7, 62.1.9, 62.1.14 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хурлыг 2023 оны 04-р сарын 29-ны өдрийн 12:00 цагт <https://hural.cumongol.mn> веб хаягаар Zoom платформ ашиглан цахим хэлбэрээр хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
  - (i) Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
  - (ii) Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн гаргасан дүгнэлтийг батлах;
  - (iii) Компанийн 2022 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах;
  - (iv) Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх;
  - (v) Компаниас нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх;
  - (vi) Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх;
  - (vii) Компанийн нэмэлт өөрчлөлт орсон Дүрмийн төслийг батлах; болон
  - (viii) ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилох.
3. Хурлын зарыг 2023 оны 03-р сарын 23-ны өдөр, давтан зарыг 2023 оны 04-р сарын 10-ны өдөр тус тус өдөр тутмын сонин, Компани болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
4. Хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх саналын хуудасны загвар, Хурлаас гарах шийдвэр болон Хуралтай холбоотой бусад материалыг тусгасан Хурлын материалыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 04-р сарын 10-ны өдрөөр тогтсугай.
6. Хурал хуралдуулахтай холбоотой дор дурдсан баримт бичигтэй танилцах (тогтоолын 6(iv)-т заасан баримт бичгийн хувьд Хурлын үеэр) боломжийг 2023 оны 04-р сарын 11-ны өдрөөс хувьцаа эзэмшигчдэд олгосугай. Үүнд:
  - (i) Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол;
  - (ii) Хурлын зар;
  - (iii) Хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл;

- (iv) Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
  - (v) Нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төсөл;
  - (vi) ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
  - (vii) Хурлын саналын хуудасны загвар; болон
  - (viii) Хуралд урьдчилан цахимаар санал өгөх заавар.
7. Хурлын даргаар ТУЗ-ийн дарга А.Ганхуягийг томилсугай.
8. Дор дурдсан нэр бүхий ажилтнуудыг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
- (i) Д.Бүдханд, Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер (дарга);
  - (ii) Т.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга; болон
  - (iii) Г.Батбаатар, Маркетингийн газрын захирал.
9. Дор дурдсан нэр бүхий хүмүүсийг Хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
- (i) Н.Нарангэрэл, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалтыг газрын захирал (дарга);
  - (ii) Н.Халиунгоо, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер; болон
  - (iii) А.Намуун, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч.
10. Хурлын материалыг 2023 оны 03-р сарын 24-ний өдөр брокерын компаниуд болох Голомт Капитал ҮЦК ХХК болон Апекс Капитал ҮЦК ХХК-д хүргүүлсүгэй.
11. Хуралд урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2023 оны 04-р сарын 11-ний өдрөөс 04-р сарын 28-ны өдрийн хооронд <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх линк, нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээсний үндсэн дээр дээрх өдрүүдэд цахимаар хүлээн авахаар шийдвэрлэсүгэй.
12. Хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
13. Хурлын мэдэгдлийг 2023 оны 03-р сарын 22-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А.ГАНБОЛД			
	О.БАТМӨНХ			
	Г.БАТ-ЭРДЭНЭ			
	Г.ЧИНЗОРИГ			
	Б.БАТ-ЭРДЭНЭ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Н.ЭНХБОЛД			
	В.ГАНЗОРИГ			
	ГАРИ СТИВЕН БИОНДО			
Тогтоолын батлагдсан хувь:		100%		